

**ТӨРИЙН АЛБА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААР
ТӨВ АЙМГИЙН ИРГЭДЭЭС АВСАН САНАЛ АСУУЛГЫН
ДҮНГИЙН ТУХАЙ**

2010.03.25

Зуунмод

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу төр засгийн бодлого шийдвэр орон нутагт хэрхэн хэрэгжиж байгаа болон төрийн алба үйлчилгээний байдалд дүгнэлт өгөх зорилгоор аймгийн насанд хүрсэн нийт иргэдийн 5 хүртэл хувийг хамруулав. Санал асуулгыг ШУА-ын Философи социологийн эрхийн хүрээлэнгийн мэргэжилтэнтэй хамтран боловсруулж, 2010 оны 1 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд “Үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих жил”-ийн ажлын нээлтийг 27 суманд зохион байгуулах үеэр иргэд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан сумдын иргэдээс авч дүгнэлээ.

Санал асуулга нь Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэнд өгөх дүгнэлт, төрийн байгууллагын үнэлэлт гэсэн 4 хэсэгтэй.

Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хүрээнд 4.75, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 4.62, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 4.84, төрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд 4.68 буюу дөрвөн хэсгийн дундаж үнэлгээ **4.72**

Санал асуулганд 2785 иргэн оролцсоноос 18-35 насны 743 /26.7%/, 36-50 насны 1204 /43.2%/, 51-с дээш насны 838 /30.1%/ хүн байна. Үүнээс дээд боловсролтой 754 /27.1%/, тусгай дунд боловсролтой 209 /7.5%/, бүрэн дунд 1144 /41.1%/, дунд 493 /17.7%/, бага боловсролтой 127/4.6%/, боловсролгүй 58/2.1%.

Хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэрийн хэрэгжилтийн талаар санал асуулганд оролцсон иргэдийн 1359 буюу 48.8% нь бүрэн хангалттай, 1287 буюу 46.2% нь хангалттай, 55 буюу 2% төдийлөн хангалттай бус, 61 буюу 2.2% нь хангалтгүй, 23 буюу 0.8% нь мэдэхгүй гэж дүгнэв.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар нийт оролцогсдын 1598 буюу 57.4% бүрэн хангалттай, 972 буюу 34.9% хангалттай, 163 буюу 5.9% төдийлөн хангалттай бус, 40 буюу 1.4% нь хангалтгүй, 12 буюу 0.4% нь мэдэхгүй гэж дүгнэсэн байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудаас Төрөөс иргэдэд үзүүлж байгаа нийгмийн халамжийн үйлчилгээний хүртээмж, “Атрын 3 дахь аян”-ы хэрэгжилтэнд иргэдийн 72.3-91.4% нь хангалттай хэрэгжиж байна гэж дүгнэлээ.

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар 1581 буюу 56.8% нь бүрэн хангалттай, 1113 буюу 40% нь хангалттай, 57 буюу 2.1% нь төдийлөн хангалттай бус, 24 буюу 0.9% нь хангалтгүй, 10 буюу 0.4% нь мэдэхгүй гэж дүгнэсэн байна. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар хийж байгаа ажлын үр дүн, газар тариалангийн үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэлийг дэмжих талаар авч байгаа арга хэмжээний талаар иргэдийн 80-95% нь сэтгэл ханамж өндөртэй байна. Санал асуулганд хамрагдагсдаас 455 буюу 16.3% нь ядуурлыг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр ямар нэгэн төсөл хөтөлбөр, зээл, тусламжинд хамрагдсан байв.

Төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний талаар 1398 буюу 50.2% нь онц, 1209 буюу 43.4% нь сайн, 86 буюу 3.1% нь дунд, 73 буюу 2.6% нь муу, 19 буюу 0.7% нь мэдэхгүй гэж дүгнэлээ.

Мөн иргэдээс байгаль орчныг хамгаалах, бэлчээрийн хүртээмж, цөлжилттэй тэмцэх талаар анхаарч ажиллах талаар санал гаргасан байв.

ТӨВ АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА

Р.БОЛД